

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021 оны 03 дүгээр сарын 11-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **12Х18Н10Т материалтай лист, бөөрөнхий төмөр нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДЦС4/2021-87**

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **12Х18Н10Т материалтай лист, бөөрөнхий төмөр** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**1. Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2019 он, 2020 он/

**2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

**3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил:** Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 онд ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

Тендерийн хамт төсөвт өртгийн үнийн дүнгийн 2%-тай тэнцүү буюу 12,302,507 төгрөг 66 мөнгөний тендерийн баталгаа ирүүлнэ.

**Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.**


Тендерийг 2021 оны 04 дугаар сарын 12-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 04 дугаар сарын 12-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ТӨМӨРХУЯГ